төлөвлөлтийн шатанд урьдчилан тооцож, төсвийн саналд тусган батлуулаагүйгээс бараа үйлчилгээний бусад зардлын ангиллаас 27,235.6 мянган төгрөг, мэдээлэл, технологийн үйлчилгээний зардлын ангиллаас 10,941.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын ангиллаас 1,643.2 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардлаас 56,891.1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

4. Тайлант онд Удирдлагын академийн Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 6, Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 3, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 9, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 7, Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 1 албан хаагчийг тус тус хамруулсан байна.

Бусад цаг үеийн шинжтэй 5 төрлийн сургалтыг зохион байгуулж, нийт 6,882.0 мянган төгрөгийн зарцуулсан байна. Үүнд судалгааны арга зүй эзэмших, төрийн худалдан авах ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдал, ёс зүй, хувь хүний хөгжил, төрийн албан хэрэг хөтлөлт зэрэг сэдэвт сургалт хамарчээ.

5. Тайлант онд яамны үндсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор нийт 6 байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 118,220.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Үүнд:

- МУ-ын хууль тогтоомжид нийцүүлэн АҮЭБ салбарын судалгаа, статистик мэдээ, мэдээлэл бэлтгэх, олон нийтийг нээлттэй, ил тод мэдээллээр хангаж сурталчлан таниулах зорилгоор newslife.mn, mining.mn, livetv.mn, 24tsag.mn, mass.mn, tsenzuur.mn сайтад мэдээ, мэдээлэл байршуулахад 39,330.0 мянган төгрөг,
- АҮЭБЯ-ны үйл ажиллаатай холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэх, зөвшөөрсөн мэдээллийг tsenzuur.mn, 24tsag.mn, mining.mn, newslife.mn, zogii.mn, livetv.mn, tsahiur.mn, mass.mn, ubn.mn, zarig.mn, tsahimnews.mn сайтад байршуулахад 59,080.0 мянган төгрөг,
- Салбарын мэдээ, мэдээллийг сурталчлан таниулах зорилгоор tsahimnews.mn сайтад мэдээ, мэдээлэл байршуулахад 19,810.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу яам нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр болон аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хооронд байгуулсан “Интегра” төслийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт 70,263.0 мянган төгрөг, Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор байгуулагдсан Аж үйлдвэржилтийн үндэсний хорооны 2025 онд хэрэгжүүлэх аж үйлдвэржилтийн төслүүдийн бэлтгэл хангах ажлыг зохион байгуулахад шаардагдах 1,274,813.8 мянган төгрөг, нийт 1,345,071.3 мянган төгрөгийн эх үүсвэр төвлөрсөн байна.

Дээрх эх үүсвэрээс бараа үйлчилгээний бусад зардалд 1,345,071.3 мянган төгрөгийг зарцуулсан ба 11,769.9 мянган төгрөгийг тоног төхөөрөмж, 97,071.8 мянган төгрөгийг

тавилга, эд хогшил худалдан авах зардалд, 476,225.2 мянган төгрөгийг цалин, урамшуулал, нэг удаагийн тэтгэмжийн зардалд, 111,559.3 мянган төгрөгийг гадаад, дотоод албан томилолтын зардалд, 648,440.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд зарцуулж, үлдэгдэл 5.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны А/43 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан байна. Уг төлөвлөгөөнд төсвийн хөрөнгө оруулалтын 984,000.0 мянган төгрөг, урсгал төсвийн 231,920.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний 288,035.0 мянган төгрөг, нөөц сангаас 505,700.0 мянган төгрөг, нийт 2,009,655.0 мянган төгрөгийн санхүүжилтээр 18 нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар тусгасан байна.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/79 дүгээр тушаалаар дээрх худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулан батлуулсан байна.

Төлөвлөгөөний дагуу нийт 9 удаа нээлттэй тендер сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж, нийт 648,681.4 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байна. Үүнд:

- Олборлох, үйлдвэрлэх ил тод байдлын санаачлагын 2024 оны нэгтгэл тайлан боловсруулах ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Эс Ай Си Эй” ХХК-тай 109,000.0 мянган төгрөгийн гэрээ;
- Аж үйлвэржилтийн үндэсний хорооны ажлын албаны байрны түрээсийн тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Раашбулаг” ХХК-тай 96,000.0 мянган төгрөгийн гэрээ;
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлан, шалгарсан оролцогч “Андхайрхан” ХХК-тай 134,997.5 мянган төгрөгийн гэрээ;
- Багаж, техник, хэрэгсэлийн тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Монтех дистрибьюшн” ХХК-тай 99,999.9 мянган төгрөгийн гэрээ;
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний 3 багц бүхий тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан оролцогч “Хараат бус судалгааны арвис төв”-тэй 1 дүгээр багц 29,900.0 мянган төгрөг, 2 дугаар багц 19,900.0 мянган төгрөг, “Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв”-тэй 3 дугаар багц 49,900.0 мянган төгрөгийн гэрээ;
- Ерөнхий гэрээний аргаар цахим дэлгүүрээс Компьютер худалдан авах тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Саммит Компьютер Технологи” ХХК-тай 13,984.0 мянган төгрөгийн гэрээг байгуулсан.
- Тавилга эд хогшлын тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан “Говьхангай буйдан” ХХК-тай 95,000.0 мянган төгрөгийн гэрээг тус тус байгуулсан байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны төсвийн шууд захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор үр ашиггүй зардал гаргахгүй байх, мэдээллийн аюулгүй байдлын хариуцлагыг байгууллагын одоогийн бүтэц, орон тооны хүрээнд тодорхой хуваарилах, нэвтрэх эрхийн хяналт болон хэрэглэгчийн үйлдлийн бүртгэлийг журамлан мөрдүүлэх, гэрээний дагуу гүйцэтгэж дууссан ажлын өртгийг зөв ангилан бүртгэх талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Я.Марал-Эрдэнэ нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/235 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 6,953,235.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцож, 69,532.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон, хязгаарласан гар утасны зардал, хэвлэл захиалгын төлбөр, зочин төлөөлөгч хүлээн авах тайлант онд санхүүжүүлээгүй бөгөөд хэвлэл, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардал батлагдаагүй байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, салбарын чиг үүргийн биелэлт, мэдээллийн аюулгүй байдлын удирдлага, холбогдох хууль тогтоомж, журам, дотоод зохицуулалтын шаардлагыг бүрэн хангаагүй зэрэг 6 зөрчил илэрсэн байна.

Эдгээр нь яамны хууль, эрх зүйн нийцэл, дотоод хяналт, удирдлагын хариуцлагын тогтолцоонд эрсдэл үүсгэж байгаа тул зөрчлийг арилгах, таслан зогсоох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр 2 албан шаардлага, 4 зөвлөмж өглөө.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 178 мэдээлэл байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", гэж заасантай нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд нь бүрэн байршуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

**Илрүүлэлт 1:** Тус яам нь 2025 оны санхүүгийн тайланг хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэн, Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Мөн Төрийн Аудитын байгууллагад аудит ирүүлсэн санхүүгийн тайланд тодруулга, тэмдэглэлийг иж бүрэн бэлтгэж, толилуулаагүй байна.

*Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг тодруулга, тэмдэглэлийг иж бүрэн бэлтгээгүй зөрчлийг таслан зогсоох тухай албан шаардлага хүргүүлсэн.

**Илрүүлэлт 2:** Тайлант хугацаанд яамнаас гаргасан захирамжлалын болон зохион байгуулалтын шинжтэй нийт 78 -А, 24-Б тушаалыг эрх бүхий албан тушаалтан гарын үсгийн дардсаар баталгаажуулсан байна.

*Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2-т "Байгууллагын зохион байгуулалтын нэгж /газар, хэлтэс/-ийн дарга албан хэрэг*

хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, журам, стандартыг өөрийн хариуцсан нэгжийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулж, цаасан болон цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байх, үнэн зөв байх, бүрэн бүрдэлтэй, ашиглах боломжтой байхад хяналт тавина.", Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолын хавсралт "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2.7-д "захирамжлалын, зохион байгуулалтын болон мэдээлэл-лавлагааны баримт бичгийг хянаж, цахим баримт бичгийг цахим гарын үсгээр, цаасан баримт бичигт гарын үсэг зурж тамга, тэмдгээр тус тус баталгаажуулах", 8.1-т "Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 48.2-т зааснаас гадна дараах зүйлийг хориглоно", 8.1.3-т "байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн захирамжлалын, зохион байгуулалт болон мэдээлэл-лавлагааны баримт бичгийг эрх бүхий албан тушаалтны гарын үсгийн дардсаар баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Тушаал, шийдвэрийн баталгаажуулалттай холбоотой дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулж, баримт бичгийн хүчин төгөлдөр байдалд хяналт тавьж ажиллах зөвлөмж өгсөн.

**Илрүүлэлт 3:** Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын хяналтын тогтолцоо хангалтгүй байгаа нь мэдээллийн системийн найдвартай ажиллагаа, өгөгдлийн хамгаалалт, санхүүгийн мэдээллийн үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна. Тодруулбал:

- Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам болон холбогдох хууль, эрх зүйн актуудыг бүх албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтийг хянах, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна. Мэдээллийн аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан томилоогүй бөгөөд хэрэгжилтийн хяналт, тайлагнал тогтмол хийгдээгүй;
- Сервер болон мэдээллийн бааз доголдсон үед үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх сэргээн босголтын нөөц систем, төлөвлөгөө боловсруулаагүй, баталгаажуулсан баримт бичиггүй байна. Мөн кибер халдлагын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө (Incident Response Plan) батлагдаагүй бөгөөд туршилт, сорилт хийгдээгүй;
- Санхүүгийн болон бусад мэдээллийн системд нэвтрэх эрхийн хяналт сул, хэрэглэгчийн эрхийн түвшинг тодорхойлсон журам бүрэн мөрдөгдөөгүй байна. Хэрэглэгчийн үйлдлийн лог бүртгэл хангалтгүй, систем дотор хийгдсэн бүх үйлдэл, өөрчлөлт, гүйлгээг цаг хугацааны дарааллаар бүртгэж хадгалах зохицуулалт бүрдээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам"-ын 1.2, 2.1.2, 4.16, 4.17, 7.1 заалттай нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Мэдээллийн аюулгүй байдлын хариуцлагыг байгууллагын одоогийн бүтэц, орон тооны хүрээнд тодорхой хуваарилж, эрх, үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусган баталгаажуулах, мэдээллийн системийн тасралтгүй ажиллагаа болон кибер халдлагын үеийн хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж хэрэгжүүлэх, нэвтрэх эрхийн хяналт болон хэрэглэгчийн үйлдлийн бүртгэлийг журамлан мөрдүүлж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавих зөвлөмж өгсөн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулан, мөнгөн хөрөнгө, цалингийн зардал, бараа материал болон үндсэн хөрөнгийн дансдад аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Аудитаар нийт 4,675,693.4 мянган төгрөгийн дүн бүхий 13 алдаа, зөрчил илэрсэн бөгөөд эдгээр асуудлын хэрэгжилт хангалтгүй 11 асуудлыг жилийн эцсийн аудитаар дахин хянан шалгаж, аудитын тайланд тусгасан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 60,809.4 мянган төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 465,853.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 10 албан шаардлага хүргүүлэн, 794,553.4 мянган төгрөгийн 6 асуудлаар зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг хянаж, үнэлэхэд 72.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

№	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	6	60,809.4	2	37,000.0	33.3
2	Албан шаардлага	10	465,853.0	9	465,853.0	95.0
3	Зөвлөмж	6	794,533.4	5	663,216.4	83.3
<b>Нийт дүн</b>		<b>22</b>	<b>1,321,195.8</b>	<b>16</b>	<b>1,166,069.4</b>	<b>72.7</b>

Тайлант оны аудитаар бүрэн хэрэгжээгүй нийт 4 төлбөрийн акт, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй төсвийн шууд захирагчийн нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага, 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэхээр тус тус шийдвэрлэсэн.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

- Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор Аж үйлдвэржилтийн үндэсний хороог байгуулж, 2025 онд хэрэгжүүлэх аж үйлдвэржилтийн төслүүдийн бэлтгэл хангах ажлыг зохион байгуулахад шаардагдах нийт 2,645,918.5 мянган төгрөгийн санхүүжилтийг Засгийн газрын 2025 оны 55 дугаар тогтоолоор Засгийн газрын нөөц сангаас олгохоор шийдвэрлэсэн байна. Тус шийдвэр нь “Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д заасан төсөвт тусгагдаагүй, гэнэтийн болон зайлшгүй шаардлагатай нөхцөл байдлын үед ашиглах тухай шаардлагыг зөрчсөн ба тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 1,274,813.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос, нийт 766,598.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 189,513.3 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

*Залруулсан алдаа:*

Яамны 2025 оны санхүүгийн байдлын тайлан дахь бараа материал, авлага, урьдчилгаа дансны эцсийн үлдэгдлийн дүн нь тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийн дүнгээс нийт 189,513.3 зөрүүтэй тайлагнасан.

*Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, УСНББОУС-1, 17 дугаар заалттай нийцээгүй, үнэн зөв байх батламж мэдээдлийг хангаагүй.*

Аудитаар нийт 3,567,516.6 мянган төгрөгийн 12 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1,130.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 566,833.2 мянган төгрөгийн 9 албан шаардлага хүргүүлж, 2,999,553.4 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 1 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн 3,567,516.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/32, А/80, А/111 дүгээр тус тус тушаалын дагуу албан хаагчдад дотоод томилолтын зардал олгохдоо баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 1,130.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаал "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай"-г мөрдөөгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Дотоод томилолтын зардлыг илүү тооцож олгосон нийт 1,130.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

### 5.2 Албан шаардлага

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн "Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай" 66 дугаар тогтоолын дагуу "Засгийн газрын авто бааз" ТӨААТҮГ-т 0620УБМ улсын дугаартай тээврийн хэрэгслийг шилжүүлж, данс бүртгэлээс хассан байхад тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр тушаалаар баталсан "Авто зогсоол түрээсийн гэрээ"-ний дагуу 2025 оны 1, 2 дугаар улиралд нийт 2,112.0 мянган төгрөгийг авто зогсоолын түрээсийн төлбөрийг шилжүүлсэн байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.*

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Авто зогсоолын түрээсийн гэрээг цуцлаагүй, төлбөрийг шилжүүлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3778 УКН улсын дугаартай “Nissan Patrol Y63” маркийн тээврийн хэрэгслийг сайдын албан хэрэгцээнд ашигласан бөгөөд уг тээврийн хэрэгсэлтэй холбоотой яамны төсөвт тусгагдаагүй 2,772.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Төсөвт тусгагдаагүй зардал гаргаж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

3. Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант оны эцэст нийт 12,890.8 мянган төгрөгийн авлага, 215,427.5 мянган төгрөгийн өр төлбөр өглөгийг үүсгэсэн байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;”, 70 дугаар зүйлийн 70.5-д “Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно” гэж тус тус заасантай нийцээгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Тайлант оны эцэст авлага, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант онд төсвөөс нийт 19 удаагийн төлөвлөгөөт бус гадаад томилолтод 96,819.1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд эдгээр зардлыг төсвийн төлөвлөлтийн шатанд урьдчилан тооцож, төсвийн саналд тусган батлуулаагүй байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төлөвлөлтийг бодит тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулах, зардлыг батлагдсан эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах талаар албан шаардлага хүргүүлсэн

5. Тайлант онд гадаад томилолтын зардалд Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар тогтоосон зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 16,494.3 мянган төгрөгийг олгосон байна.

*Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 5.1.3-т санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ, 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Гадаад оронд болох хурал, зөвлөгөөн, уулзалт*

*яармагт оролцох, гэрээ хэлэлцээр хийх, туршлага судлах зэрэг ажлаар гадаад оронд явагчдын гадаад албан томилолтын зам хоног, зочид буудлын зардлын хэмжээ"-г мөрдөөгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан гадаад томилолтын зардлын хэмжээг мөрдөөгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

6. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/118, А/119 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 23,387.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг харилцагч байгууллагаас шууд худалдан авсан байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална." гэж заасантай нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгийг шууд худалдан авсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

7. Тайлант онд яамны үндсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хуваах замаар нийт 6 байгууллагатай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж 118,220.0 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

8. Яам нь олон нийтэд мэдээлэл сурталчлах үйлчилгээ авахдаа гүйцэтгэгчийг тухайн ажлын мэргэжлийн чиглэл, салбарын хамаарал, туршлага, чадавхад үндэслэн сонгон шалгаруулах шаардлагыг хангаагүй, улсын бүртгэлд тусгагдсан үндсэн үйл ажиллагааны чиглэл нь хэвлэл мэдээ, мэдээлэл түгээх үйлчилгээтэй нийцэхгүй 4 хуулийн этгээдээр нийт 78,710.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлсэн байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-т "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх*

*талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.”, гэж заасантай нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ гүйцэтгэсэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа холбогдох хууль, журмын дагуу үйл ажиллагааны чиглэлийг анхаараагүй, хянаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

9. Гадаад болон дотоод томилолтын зардлын зарцуулалттай холбоотой анхан шатны баримт, тухайлбал илтгэх хуудас, томилолтын тайлан, автомашин хөлсөлсөн тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээ, шатахуун худалдан авалтын баримт, жолоочийн замын хуудас зэрэг анхан шатны баримтын бүрдлийг хангуулж хүлээн авах, хянаж баталгаажуулах үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.7-т “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн 2.4-т “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Гадаад болон дотоод томилолтын зардалтай холбоотой анхан шатны баримтын бүрдлийг / илтгэх хуудас, томилолтын тайлан, автомашин хөлсөлсөн тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээ, шатахуун худалдан авалтын баримт, жолоочийн замын хуудас/ хангуулаагүй, баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох тухай албан шаардлага хүргүүлсэн.

10. Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 23,809.4 мянган төгрөгийн дараах зөрчилд тогтоосон 4 төлбөрийн актыг барагдуулаагүй, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2024 оны Б/03 дугаар тушаалаар албан хаагчдын хагас жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 85 аас доош оноо авсан 5 албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг олгохдоо маш сайн ангилалд хамрагдсан албан хаагчид олгох мөнгөн урамшууллын 50 хувиар бодож олголгүйгээр 100 хувиар тооцож илүү олгосон 4,832.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Геологийн судалгааны ажилтай холбоотой онгоцны тийзний буцаалт 2,770.4 мянган төгрөг нь өмнөх онд байгууллагын дансанд андуурагдан орсон бөгөөд улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Геофизикийн цогцолбор судалгааны ажил нь 2023 онд хийгдэж дууссан бөгөөд захиалагчийн хяналтын зардлын зарцуулагдаагүй үлдэгдэл 15,217.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;
- Цалингийн зардлаас түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд тайлант онд албан хаагчдын цалин тооцохдоо томилолтоор явсан 9 албан хаагчдад хоол, унааны зардлыг давхардуулан тооцож олгосон 989.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй;

- Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар үлдэх өртөггүй боловч үйл ажиллагаа нь хэвийн ашиглагдаж байгаа 195 ширхэг 711,820.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх тухай албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй.

*Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Аудит хийх журам”-ын 19.1-д “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн нийт 4 төлбөрийн актыг барагдуулаагүй, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй төсвийн нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Дуусаагүй үйлдвэрлэлийн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ханбогд дүүрэгт гүйцэтгэх геофизикийн судалгааны цогцолбор ажил” төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зохион байгуулж, “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ-ийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна. Гэрээний дагуу 2023 онд 2,999,553.4 мянган төгрөгийн өртөг бүхий ажлыг гүйцэтгэж дууссан боловч уг ажил тайлант оны байдлаар дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэлтэй хэвээр байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Иргэний хуулийн 206 дугаар зүйлийн 206.1-д “Үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ”, 208 дугаар зүйлийн 208.1-д “Үүргийг хууль буюу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэнэ”, 211 дүгээр зүйлийн 211.1-д “Үүргийн гүйцэтгэлийг үүрэг гүйцэтгүүлэгчид, эсхүл хууль, гэрээ буюу шүүх, арбитрын шийдвэрт заасан эрх бүхий этгээдэд хүлээлгэж өгнө” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.*

Өгсөн зөвлөмж: Гэрээний дагуу гүйцэтгэж дууссан ажлын өртгийг стандарт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн дуусаагүй үйлдвэрлэлийн данснаас шилжүүлж, зөв ангилан бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Санхүүгийн байдлын тайлан /СТ-1/ дахь бараа материал, авлага, урьдчилгаа дансны эцсийн үлдэгдлийн дүн нь тодруулга тайлангийн эцсийн үлдэгдлийн дүнгээс зөрүүтэй тайлагнасан байна.	1	189,513.3			1	189,513.3	1	189,513.3		
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>189,513.3</b>			<b>1</b>	<b>189,513.3</b>	<b>1</b>	<b>189,513.3</b>		

### 6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дотоод томилолтын зардал олгохдоо Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/52 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 1,130.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.	1	1,130.0	1	1,130.0						
2	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 01 дүгээр тушаалаар баталсан “Авто зогсоол түрээсийн гэрээ”-ний дагуу тус яаманд бүртгэлтэй 0620УБМ улсын дугаартай тээврийн хэрэгслийн авто зогсоолыг сарын 352.0 мянган төгрөгийн	1	2,112.0			1	2,112.0				

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлан

	төлбөртэйгөөр түрээслэхээр гэрээ байгуулсан байна. Гэвч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн “Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” 66 дугаар тогтоолын дагуу уг тээврийн хэрэгсэл “Засгийн газрын авто бааз” ТӨААТҮГ-т шилжиж, яамны үндсэн хөрөнгийн бүртгэлээс хасагдсан байхад 2025 оны 1, 2 дугаар улиралд нийт 2,112.0 мянган төгрөгийг авто зогсоолын түрээсийн төлбөрт шилжүүлсэн байна.									
3	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Ашигт малтмал, газрын тосны газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3778 УКН улсын дугаартай “Nissan Patrol Y63” маркийн тээврийн хэрэгслийг сайдын албан хэрэгцээнд ашигласан бөгөөд уг тээврийн хэрэгсэлтэй холбоотойгоор яамны батлагдсан төсөвт тусгагдаагүй 2,772.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	2,772.0			1	2,772.0			
4	Төсвийг зохистой удирдаагүйгээс тайлант оны эцэст нийт 12,890.8 мянган төгрөгийн авлага, 215,427.5 мянган төгрөгийн өр төлбөр өглөгийг үүсгэсэн байна	1	228,318.3			1	228,318.3			
5	Тайлант онд яамны батлагдсан төсвөөс нийт 19 удаагийн төлөвлөгөөт бус гадаад томилолтод 96,819.1 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд эдгээр зардлыг төсвийн төлөвлөлтийн шатанд урьдчилан тооцож, төсвийн саналд тусган батлуулаагүйгээс батлагдсан төсвийн хүрээнд санхүүжүүлэх зохицуулалт хангагдаагүй байна.	1	96,819.1			1	96,819.1			

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлан

6	Тайлант онд гадаад томилолтын зардал олгохдоо Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 16,494.3 мянган төгрөгийг олгосон байна.	1	16,494.3			1	16,494.3				
7	Аж үйлвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/118, А/119 дугаар тушаалаар төсөвт өртгийг хувааж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй нийт 23,387.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг харилцагч байгууллагаас шууд худалдан авсан байна.	1	23,387.3			1	23,387.3				
8	Тайлант онд яамны үндсэн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор худалдан авах ажиллагааг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хуваах замаар нийт 6 байгууллагатай шууд гэрээ байгуулж 118,220.0 мянган төгрөгийн төлбөрийг шилжүүлсэн байна.	1	118,220.0			1	118,220.0				
9	Яам нь олон нийтэд мэдээлэл сурталчлах үйлчилгээ худалдан авахдаа гүйцэтгэгчийг тухайн ажлын мэргэжлийн чиглэл, салбарын хамаарал, туршлага, чадавхад үндэслэн сонгон шалгаруулах шаардлагыг хангаагүй бөгөөд улсын бүртгэлд тусгагдсан үндсэн үйл ажиллагааны чиглэл нь хэвлэл мэдээлэл, мэдээлэл түгээх үйлчилгээтэй нийцэхгүй 4 хуулийн этгээдээр нийт 78,710.0 мянган төгрөгийн ажил гүйцэтгүүлсэн байна.	1	78,710.0			1	78,710.0				
10	Яам нь гадаад болон дотоод томилолтын зардлын зарцуулалттай холбоотой анхан шатны баримт,	1	-			1	-				

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлийн аудитын тайлан

	тухайлбал томилолтын тайлан, автомашин хөлсөлсөн тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээ, шатахуун худалдан авалтын баримт, жолоочийн замын хуудас, илтгэх хуудас зэрэг нотлох баримтыг бүрэн бүрдүүлж хүлээн авах, баталгаажуулах, хянан шалгах ажиллагаа хангалтгүй, нягтлан бодогч анхан шатны баримтын бүрдэл, гүйлгээний үнэн зөв, бодит байдлыг шалган баталгаажуулах үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.										
11	Өмнөх оны аудитаар илэрсэн нийт 23,809.4 мянган төгрөгийн дараах зөрчилд тогтоосон 4 төлбөрийн актыг барагдуулаагүй, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.								1		-
12	2023 онд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Ханбогд дүүрэгт гүйцэтгэх геофизикийн судалгааны цогцолбор ажил” төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зохион байгуулж, “Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ-ийг гүйцэтгэгчээр шалгаруулсан байна. Гэрээний дагуу 2,999,553.4 мянган төгрөгийн өртөг бүхий ажлыг гүйцэтгэж дууссан боловч уг ажил тайлант оны байдлаар дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд бүртгэлтэй хэвээр байна.	1	2,999,553.4					1	2,999,553.4		
<b>Дүн</b>		<b>12</b>	<b>3,567,516.4</b>	<b>1</b>	<b>1,130.0</b>	<b>9</b>	<b>566,833.0</b>	<b>1</b>	<b>2,999,553.4</b>	<b>1</b>	<b>-</b>

**1.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шилэн дансны цахим хуудсанд нийт 178 мэдээлэл байршуулахаас 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	1	-		
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>		
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам нь 2025 оны санхүүгийн тайланг хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэн, Үндэсний аудитын газарт 2026 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр хугацаа хоцроон ирүүлсэн байна. Мөн Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн Аудитын байгууллагад аудит хүргүүлсэн санхүүгийн тайланд тодруулга, тэмдэглэлийг иж бүрэн бэлтгэж, толилуулаагүй байна.	1	-	1	-		
2	Тайлант хугацаанд яамнаас гаргасан захирамжлалын болон зохион байгуулалтын шинжтэй нийт 78 ‘А’, 24 ‘Б’ тушаалыг эрх бүхий албан тушаалтан гарын үсгийн дардсаар баталгаажуулсан байна. Хяналт-шинжилгээний дүнгээс үзвэл эрх бүхий албан тушаалтны гаргасан баримт бичгийн хүчин төгөлдөр байдалд эргэлзээ үүсэх, дотоод хяналтын тогтолцоо сулрах эрсдэлтэй байна.	1	-			1	-
3	Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам болон холбогдох хууль, эрх зүйн актуудыг бүх албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтийг хянах, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна. Мэдээллийн аюулгүй байдлын асуудал хариуцсан нэгж, албан тушаалтан томилоогүй бөгөөд хэрэгжилтийн хяналт, тайлагнал тогтмол хийгдээгүй байна.	1	-			1	-
4	Сервер болон мэдээллийн бааз доголдсон үед үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх сэргээн босголтын нөөц систем, төлөвлөгөө боловсруулаагүй, баталгаажуулсан баримт бичиггүй байна. Мөн кибер халдлагын үед авах хариу арга хэмжээний төлөвлөгөө (Incident Response Plan) батлагдаагүй бөгөөд туршилт, сорилт хийгдээгүй байна.	1	-			1	-
5	Санхүүгийн болон бусад мэдээллийн системд нэвтрэх эрхийн хяналт сул, хэрэглэгчийн эрхийн түвшинг тодорхойлсон журам бүрэн мөрдөгдөөгүй байна. Хэрэглэгчийн үйлдлийн лог бүртгэл хангалтгүй, систем дотор хийгдсэн бүх үйлдэл, өөрчлөлт, гүйлгээг цаг хугацааны дарааллаар бүртгэж хадгалах зохицуулалт бүрдээгүй байна.	1	-			1	-
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>		<b>6</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 79/A0171239

Улаанбаатар хот

САГ - 2026/3/ИА - СТА - ТИЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дотоод томилолтын зардал олгохдоо Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаалаар баталсан зардлын хэмжээг мөрдөөгүй нийт 1,130,000.00 /Нэг сая нэг зуун гучин мянган/ төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2-т "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Сангийн сайдын 2024 оны А/52 дугаар тушаал "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай"-г мөрдөөгүй байна.

